

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Монгол Улсын Их Хурлын даргын төсвийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/11/НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2026 он	Тусгай чиг үүргийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор: Д.Баярсайхан Утас: 329872 Цахим хаяг: <a href="mailto:bayarsaikhand@audit.gov.mn">bayarsaikhand@audit.gov.mn</a> Аудитын менежер: В.Эрдэнэцогт Утас: 261663 Цахим хаяг: <a href="mailto:erdenetsogtv@audit.gov.mn">erdenetsogtv@audit.gov.mn</a> Аудитор: Г.Батбилэг Утас: 261663 Цахим хаяг: <a href="mailto:batbilegg@audit.gov.mn">batbilegg@audit.gov.mn</a>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан .....	5
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	7
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	8
3.1 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний үйл ажиллагаа .....	8
3.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн гадаад, дотоод орчин.....	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	9
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	9
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	12
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	14
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.2 Материаллаг байдал .....	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	16
5.1 Төсвийн шууд захирагчид.....	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	18

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
ПИБТ	Парламентын Институцийг Бэхжүүлэх нь Төсөл
ОУ	Олон Улс
ОУПХ	Олон Улсын Парламентын Холбоо
УИХ	Улсын Их Хурал
УИХТГ	Улсын Их Хурлын Тамгын Газар
ТӨБЗГ	Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон Орон Нутгийн Өмчийн Хөрөнгөөр Бараа, Ажил, Үйлчилгээ Худалдан Авах Тухай Хууль



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА  
САНДАГИЙН БЯМБАЦОГТ ТАНАА

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

Засгийн газрын IV байр, Бага тойруу-3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26-04-37, Факс: (976-51) 26 42 30  
Цахим шуудан: info@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2026.04.27 № 1141  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Монгол Улсын Их Хурлын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу, хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд 2025 онд өөрчлөлт оруулснаар “Улсын Их Хурлын асуулгын цаг”-ийг шинээр бий болгож, Улсын Их Хурлын гишүүд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн төсөв, жилийн төлөвлөгөөний биелэлт, санхүүгийн байдал болон бусад асуудлаар Монгол Улсын Ерөнхий сайдад асуулт тавих зохицуулалтыг хэрэгжүүлж эхэлжээ.

Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд “Улсын Их Хурлын асуулгын цаг”-ийг нийт дөрвөн удаа зохион байгуулсан бөгөөд асуулгын цагийн талаарх мэдээлэл, холбогдох хууль, эрх зүйн лавлагаа, түүнчлэн Улсын Их Хурлын даргад ирүүлсэн гишүүдийн асуултыг тухай бүр нэгтгэн Монгол Улсын Ерөнхий сайдад хүргүүлэн, хариулт авч байна. Ингэснээр хууль тогтоох дээд байгууллагаас хуулийн биелэлтэд хяналт тавих бүрэн эрхээ хэрэгжүүлэхийн зэрэгцээ нээлттэй, тэгш, чөлөөт мэтгэлцээн, үзэл бодлын өрсөлдөөний шинэ соёл төлөвшихөд дэмжлэг үзүүлж байна.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал

Z:\Yawsan\_Bichig\2026\0424 SAG-26 Docx

1526090606

байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд 2025 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу Улсын Их Хурлын байнгын хороодын бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн, өмнө нь үйл ажиллагаа явуулж байсан 11 байнгын хороог 8 болгон цөөлж баталснаар төсвийн зардлыг хэмнэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Хууль тогтоомж хоорондын зөрчил, давхардлыг илрүүлэх хиймэл оюун ухаанд (AI) суурилсан хууль зүйн дүн шинжилгээний чиглэлээр 2025 онд бодит ахиц дэвшил гаргасан байна. Тодруулбал хүчин төгөлдөр мөрдөж буй 378 хууль болон тэдгээрт хамаарах 50 мянга гаруй зүйл, заалтыг хамруулан дүн шинжилгээ хийж, зөрчил, давхардлыг илрүүлэх боломж бүхий шийдлийг боловсруулан практикт нэвтрүүлж эхэлжээ.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гараагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



С.МАГНАЙСҮРЭН

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>5,476,190.3</b>	<b>2,470,110.4</b>
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>3,450,847.7</b>	<b>319,801.6</b>
33	<b>АВЛАГА</b>	<b>74,674.0</b>	<b>675,313.0</b>
34	<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>893,662.0</b>	<b>289,500.0</b>
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>1,057,006.6</b>	<b>1,185,495.8</b>
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>26,505,812.0</b>	<b>27,141,575.3</b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>26,505,812.0</b>	<b>27,141,575.3</b>
39200	Биет хөрөнгө	25,118,598.2	25,969,383.5
39300	Биет бус хөрөнгө	1,387,213.8	1,172,191.8
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2</b>	<b>31,982,002.2</b>	<b>29,611,685.7</b>
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>992,623.6</b>	<b>633,778.5</b>
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>992,623.6</b>	<b>633,778.5</b>
41300	Өглөг	992,623.6	633,778.5
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>30,989,378.7</b>	<b>28,977,907.2</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>30,989,378.7</b>	<b>28,977,907.2</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	3,560,849.8	3,560,849.8
51200	Хуримтлагдсан үр дүн	27,428,528.9	25,417,057.4
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5</b>	<b>31,982,002.2</b>	<b>29,611,685.7</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>149,637,051.2</b>	<b>157,884,023.0</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,482,772.7</b>	<b>157,884,023.0</b>
122	Тусламжийн орлого	703,026.5	157,539,780.4
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>146,154,278.5</b>	-
II	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>130,741,200.5</b>	<b>159,880,803.1</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>125,185,634.2</b>	<b>156,929,867.4</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>101,821,405.7</b>	<b>121,985,312.7</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	41,566,477.5	54,796,731.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,082,562.6	6,664,354.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,839.4	85,463.8
2104	Хангамж, бараа материалын зардал	2,835,024.6	2,489,123.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	466,234.0	654,217.9
2107	Томилолт, зочны зардал	4,575,125.1	5,797,887.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	9,137,501.6	12,101,157.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38,132,640.9	39,396,377.0
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>23,364,228.5</b>	<b>34,944,554.7</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>5,555,566.3</b>	<b>2,950,935.7</b>

III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	18,895,850.7	(1,996,780.2)
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	13,369.8	14,691.3
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	(13,369.8)	(14,691.3)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	18,882,481.0	(2,011,471.5)

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	12,106,897.7	-	12,106,897.7
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	12,106,897.7	-	12,106,897.7
3	Тайлант үеийн үр дүн	18,882,481.0	-	18,882,481.0
4	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	30,989,378.7	-	30,989,378.7
5	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	30,989,378.7	-	30,989,378.7
6	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	30,989,378.7	-	30,989,378.7
7	Тайлант үеийн үр дүн	(2,011,471.5)	-	(2,011,471.5)
8	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	28,977,907.2	-	28,977,907.2

### 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	149,617,657.5	157,992,912.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,127,492.7	157,992,912.5
120	Нийтлэг татварын бус орлого	561,654.2	446,030.1
122	Тусламжийн орлого	565,838.5	157,546,882.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	148,490,164.8	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	126,446,958.2	153,741,335.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	126,446,958.2	153,741,335.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	100,842,448.1	118,211,304.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	41,567,895.3	54,785,329.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,083,396.5	6,664,354.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	59,187.4	52,115.9
2104	Хангамж, бараа материалын зардал	3,003,638.1	2,451,785.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	497,812.4	651,617.3
2107	Томилолт, зочны зардал	4,575,125.2	6,207,881.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	10,028,454.0	11,560,659.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	36,026,939.3	35,837,561.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,604,510.1	35,530,030.9
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	23,170,699.4	4,251,576.8

<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>20,802,529.6</b>	<b>7,382,622.9</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>20,802,529.6</b>	<b>7,382,622.9</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	20,802,529.6	7,382,622.9
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(20,802,529.6)</b>	<b>(7,382,622.9)</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>2,368,169.8</b>	<b>(3,131,046.1)</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,082,677.9	3,450,847.7
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,450,847.7	319,801.6

## 2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>1</b>	<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>162,020,544,200.00</b>	<b>124,675,650,324.00</b>	<b>37,344,893,876.00</b>	<b>77.0</b>
<b>12</b>	<b>Татварын бус орлого</b>	<b>162,020,544,200.00</b>	<b>124,675,650,324.00</b>	<b>37,344,893,876.00</b>	<b>77.0</b>
120	Нийтлэг татварын бус орлого	100,000,000.00	140,879,378.84	(40,879,378.84)	140.9
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	100,000,000.00	140,879,378.84	(40,879,378.84)	140.9
122	Тусламжийн орлого	161,920,544,200.00	124,534,770,945.16	37,385,773,254.84	76.9
122005	Төсвөөс санхүүжих	161,920,544,200.00	124,534,770,945.16	37,385,773,254.84	76.9
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>162,020,544,200.00</b>	<b>124,675,650,324.00</b>	<b>37,344,893,876.00</b>	<b>77.0</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>153,460,544,200.00</b>	<b>119,401,546,655.00</b>	<b>34,058,997,545.00</b>	<b>77.8</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>149,459,750,000.00</b>	<b>117,956,767,714.56</b>	<b>31,502,982,285.44</b>	<b>78.9</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	71,862,248,400.00	54,655,372,857.20	17,206,875,542.80	76.1
210101	Үндсэн цалин	42,162,082,100.00	38,674,269,754.64	3,487,812,345.36	91.7
210102	Нэмэгдэл	24,258,380,700.00	11,533,165,591.55	12,725,215,108.45	47.5
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,196,824,500.00	2,443,247,000.89	753,577,499.11	76.4
210104	Урамшуулал	2,244,961,100.00	2,004,690,510.12	240,270,589.88	89.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,982,025,400.00	6,648,109,762.67	2,333,915,637.33	74.0
210201	Тэтгэврийн даатгал	6,088,939,300.00	4,497,711,951.89	1,591,227,348.11	73.9
210202	Тэтгэмжийн даатгал	693,288,800.00	543,055,234.09	150,233,565.91	78.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	367,094,700.00	287,445,961.98	79,648,738.02	78.3
210204	Ажилгүйдлийн даатгал	366,536,300.00	260,348,251.30	106,188,048.70	71.0
210205	Эрүүл мэндийн даатгал	1,466,166,300.00	1,059,548,363.41	406,617,936.59	72.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	298,580,700.00	52,115,873.74	246,464,826.26	17.5
210301	Гэрэл, цахилгаан	21,760,000.00	17,950,368.42	3,809,631.58	82.5
210302	Түлш, халаалт	15,561,700.00	8,668,350.34	6,893,349.66	55.7
210303	Цэвэр, бохир ус	8,790,700.00	6,359,408.00	2,431,292.00	72.3
210304	Байрны түрээс	252,468,300.00	19,137,746.98	233,330,553.02	7.6
2104	Хангамж, бараа материалын зардал	3,053,075,400.00	2,482,408,211.86	570,667,188.14	81.3
210401	Бичиг хэрэг	453,713,500.00	239,099,768.00	214,613,732.00	52.7
210402	Тээвэр, шатахуун	1,918,701,200.00	1,747,107,289.00	171,593,911.00	91.1
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	499,298,900.00	312,624,233.72	186,674,666.28	62.6
210404	Ном, хэвлэл	181,361,800.00	183,576,921.14	(2,215,121.14)	101.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	913,523,100.00	754,024,722.00	159,498,378.00	82.5
210601	Багаж, техник, хэрэгсэл	19,690,300.00	107,071,457.00	(87,381,157.00)	543.8
210602	Тавилга	20,000,000.00	14,107,600.00	5,892,400.00	70.5
210604	Урсгал засвар	873,832,800.00	632,845,665.00	240,987,135.00	72.4
2107	Томилолт, зочны зардал	9,227,962,200.00	6,090,252,663.79	3,137,709,536.21	66.0
210701	Гадаад албан томилолт	4,616,848,700.00	3,433,649,587.49	1,183,199,112.51	74.4
210702	Дотоод албан томилолт	1,554,244,300.00	890,093,755.00	664,150,545.00	57.3
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	3,056,869,200.00	1,766,509,321.30	1,290,359,878.70	57.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,280,059,900.00	11,440,736,302.52	3,839,323,597.48	74.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	12,022,997,300.00	10,790,122,307.58	1,232,874,992.42	89.7

Монгол Улсын Их Хурлын даргын төсвийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	төлбөр хураамж				
210803	Даатгалын үйлчилгээ	34,550,200.00	-	34,550,200.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	69,100.00	-	69,100.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,222,081,600.00	650,613,994.94	2,571,467,605.06	20.2
210807	Газрын төлбөр	361,700.00	-	361,700.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39,842,274,900.00	35,833,747,320.78	4,008,527,579.22	89.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	39,729,761,100.00	35,721,233,598.59	4,008,527,501.41	89.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	112,513,800.00	112,513,722.19	77.81	100.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>4,000,794,200.00</b>	<b>1,444,778,940.44</b>	<b>2,556,015,259.56</b>	<b>36.1</b>
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	55,841,400.00	55,841,400.00	-	100.0
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	55,841,400.00	55,841,400.00	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,944,952,800.00	1,388,937,540.44	2,556,015,259.56	35.2
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	393,652,600.00	6,308,000.00	387,344,600.00	1.6
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,125,414,700.00	874,328,320.00	251,086,380.00	77.7
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,974,467,000.00	339,447,102.44	1,635,019,897.56	17.2
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	451,418,500.00	168,854,118.00	282,564,382.00	37.4
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>8,560,000,000.00</b>	<b>5,274,103,669.00</b>	<b>3,285,896,331.00</b>	<b>61.6</b>
222001	Тоног төхөөрөмж	8,560,000,000.00	5,274,103,669.00	3,285,896,331.00	61.6
<b>8</b>	<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>	-	-	-	
<b>9</b>	<b>АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	-	-	
<b>7</b>	<b>Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт</b>	-	-	-	
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	<b>2,809,595,350.00</b>	<b>(2,809,595,350.00)</b>	
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>1,882.00</b>	<b>1,566.00</b>	<b>316.00</b>	<b>83.2</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>4.00</b>	<b>3.00</b>	<b>1.00</b>	<b>75.0</b>
610001	Төсвийн байгууллага	4.00	3.00	1.00	75.0
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>934.00</b>	<b>806.00</b>	<b>128.00</b>	<b>86.3</b>
620001	Удирдах ажилтан	150.00	130.00	20.00	86.7
620002	Гүйцэтгэх ажилтан	742.00	621.00	121.00	83.7
620003	Үйлчлэх ажилтан	42.00	55.00	(13.00)	131.0
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>934.00</b>	<b>756.00</b>	<b>178.00</b>	<b>80.9</b>
650003	Ажлын албаны албан хаагч (АА)	159.00	151.00	8.00	95.0
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	694.00	605.00	89.00	87.2
650014	Төрийн үйлчилгээний мэргэжлийн (ТҮМ)	81.00	-	81.00	-
<b>66</b>	<b>НИЙТ ТЭТГЭВЭРТ ГАРАГЧ</b>	<b>10.00</b>	<b>1.00</b>	<b>9.00</b>	<b>10.0</b>
660001	Төрийн албаны тухай хуулиар тэтгэвэрт гарагч	10.00	1.00	9.00	10.0

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний үйл ажиллагаа**

Улсын Их Хурлын Тамгын газрын алсын хараа: Төлөөллийн ардчиллыг бэхжүүлж, Улсын Их Хурлын хууль тогтоох, хянан шалгах чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь төрийн бодлогын залгамж чанарыг хадгалсан, шилдэг туршлагад тулгуурласан мэргэжлийн, шинэлэг, үр бүтээлтэй үйлчилгээг үзүүлнэ.

Улсын их хурал нь эрхэм зорилгоо ард түмний төлөөллийг хангаж, засаглах эрхийг хангасан парламент байна гэж тодорхойлсон.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Үүнд:

- Улсын Их Хурлын хууль тогтоох үйл ажиллагааг төгөлдөржүүлж, түүний чанар, үр нөлөөг дээшлүүлэх;
- Улсын Их Хурлын хянан шалгах үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлж, хуулийн хэрэгжилт, түүний үр нөлөөг үнэлэх байнгын тогтолцоог бүрдүүлж, чадавхжуулах;
- Улсын Их Хурал төлөөллийн чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлж, үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангаж, парламентад итгэх иргэдийн итгэлийг бэхжүүлэх;
- Улсын Их Хурлын гадаад харилцааг өргөжүүлж, парламент хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх;
- Улсын Их Хурлын чадавхыг бэхжүүлж, үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх;
- Парламентын ажлын мэргэшсэн алба Улсын Их Хурлын Тамгын газрын чадавхыг дээшлүүлж, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг боловсронгуй болгон, олон улсын жишигт хүргэх;

#### **3.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн гадаад, дотоод орчин**

Улсын Их Хурал нь Монгол Улсын Их Хурлын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татварын ерөнхий хууль болон бусад холбогдох хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд төсвийн ерөнхийлөн захирагчийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого, чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Монгол Улсын Их Хурлын тухай
- Татварын ерөнхий хууль
- Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын зорилго оршино.

Улсын Их Хурлын даргын төсвийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын 2022 оны 06 дугаар сарын 16-ны

өдрийн 348 дугаар тушаалаар баталсан байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Улсын Их Хурлын даргын төсвийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,370.3 сая төгрөгөөр буюу 7.4 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	3,450.8	319.8	(3,131.0)
Авлага	74.7	675.3	600.6
Урьдчилгаа	893.7	289.5	(604.2)
Бараа материал	1,057.0	1,185.5	128.5
Үндсэн хөрөнгө	26,505.8	27,141.6	635.8
<b>Нийт хөрөнгө</b>	<b>31,982.0</b>	<b>29,611.7</b>	<b>(2,370.3)</b>
Өр төлбөр	992.6	633.8	(358.8)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	30,989.4	28,977.9	(2,011.5)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>31,982.0</b>	<b>29,611.7</b>	<b>(2,370.3)</b>

Эх сурвалж: Улсын Их Хурлын даргын төсвийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо данснуудад материаллаг өөрчлөлт гарсан байна.

#### Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 319.8 сая төгрөг болж өмнөх оноос 3,131.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+),
			Бууралт (-)
Төрийн сангийн харилцах	3,236.5	-	(3,236.5)
Арилжааны банк дахь харилцах	214.4	319.8	105.4
<b>Дүн</b>	<b>3,450.9</b>	<b>319.8</b>	<b>(3,131.0)</b>

Эх сурвалж: Улсын Их Хурлын даргын төсвийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 3,236.5 сая төгрөгөөр буурахад он дамжин хэрэгжих хөрөнгө оруулалтын ажлын 1,923.9 сая төгрөгийг гүйцэтгэлээр санхүүжүүлсэн, барьцаа дансны үлдэгдэл 885.7 сая төгрөг, Ахмадын сангийн дансны үлдэгдэл 578.6 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн зэрэг нь голлон нөлөөлсөн байна.

Парламентын институцийг бэхжүүлэх төслийн хүрээнд Төрийн банканд 319.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгааг тулган баталгаажуулсан байна.

Аудитын илрүүлэлт:

Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой 346.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Тухайлбал: Парламентын судалгаа хөгжлийн хүрээлэн автомашингүй Засгийн газрын авто баазаас дуудлагын автомашин хэрэглэдэг байж, 2 жолооч ажиллуулж, 114.9 сая төгрөгийн цалин, нийгмийн даатгалын шитгэлийн зардал гаргасан, урсгал засварын зардлыг төсвийг 39.4 сая төгрөгөөр хэтрүүлж конторын барилгын засвар хийсэн, "Lexology судалгааны сан" байгуулах гэрээ 69.8 сая төгрөг, "ChatGPT хиймэл оюун ухааны чатбот үйлчилгээ үзүүлэх" 70.0 сая төгрөгийн гэрээг тус тус байгуулсан нь гэрээний гүйцэтгэл, үр дүн хангалтгүй.

**3.4.1 Авлага**

Авлага дансны эцсийн үлдэгдэл 675.3 сая төгрөг болж өмнөх оноос 600.6 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагсадтай холбогдсон авлага	14.5	13.1	(1.4)
Төлбөртэй үйлчилгээний авлага	58.1	79.5	21.4
Татаас санхүүжилтийн авлага	-	578.6	(578.6)
Татвар, НДШ-ын авлага	1.9	4.1	2.2
Бусад авлага	0.1	-	(0.1)
<b>Дүн</b>	<b>74.6</b>	<b>675.3</b>	<b>600.6</b>

*/сая төгрөгөөр/*

*Эх сурвалж: Улсын Их Хурлын даргын төсвийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан*

Авлагын дансны үлдэгдэл 600.6 сая төгрөгөөр өсөхөд ахмадын сангийн үлдэгдлийг буцаан төвлөрүүлсэн 578.6 сая төгрөгийг авлагаар бүртгэсэн нь голлон нөлөөлсөн байна.

Нийт үлдэгдлийн 79.5 сая төгрөг нь хэвлэх, олшруулах цехийн төлбөрт үйлчилгээний авлага, 13.1 сая төгрөг нь ажиллагсдаас авах авлага, 4.1 сая төгрөг нь нийгмийн даатгалын шимтгэлийн авлага, 578.6 сая төгрөг нь татаас, санхүүжилтийн авлага байна.

Улсын Их Хурлын Тамгын газар 672.3 сая төгрөг, Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнд 3.0 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Аудитын илрүүлэлт:

Авлагын данстай холбоотой 13.1 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Үүнд: УИХ-ын тамгын газар он дамжсан авлагын үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй 13.1 сая төгрөг байна.

**3.4.2 Урьдчилгаа**

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 289.5 сая төгрөг болж өмнөх оноос 604.2 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 4. Урьдчилгаа дансны үлдэгдэл*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	452.8	9.0	(443.8)
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	440.8	280.5	(160.3)
<b>Дүн</b>	<b>893.6</b>	<b>289.5</b>	<b>(604.2)</b>

*/сая төгрөгөөр/*

*Эх сурвалж: Улсын Их Хурлын даргын төсвийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан*

Урьдчилгаа дансны үлдэгдэлд Парламентын институцийг бэхжүүлэх нь төслийн хүрээнд бусдаар гүйцэтгүүлсэн ажлын урьдчилгаа төлбөр 9.0 сая төгрөг, Улсын Их Хурлын Тамгын газрын 2025 оны хөрөнгө оруулалтын санхүүжилтээр бэлтгэгдсэн хөрөнгийн тооцооны үлдэгдэл 280.5 сая төгрөг тус тус бүртгэлтэй байна.

### 3.4.3 Бараа материал

Бараа материал дансны үлдэгдэл 1,185.5 сая төгрөг болж 128.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Хангамжийн материал</b>	<b>1,057.0</b>	<b>1,185.5</b>	<b>128.5</b>
Бичиг хэргийн материал	137.0	113.0	(24.0)
Аж ахуйн материал	75.0	103.3	28.3
Сэлбэг хэрэгсэл	203.4	219.5	16.1
Түлш, шатах тослох материал	1.5	0	(1.5)
Хүнсний материал	6.5	0.7	(5.8)
Бусад хангамжийн материал	633.6	749.0	115.4
<b>Дүн</b>	<b>1,057.0</b>	<b>1,185.5</b>	<b>128.5</b>

Эх сурвалж: Улсын Их Хурлын даргын төсвийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 2,210.6 сая төгрөгийн бараа материал худалдан авсан, 2,082.1 сая төгрөгийн бараа материалыг зарцуулж, жилийн эцэст 1,185.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

### 3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 27,141.6 сая төгрөг болж өмнөх оноос 635.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 6. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Биет хөрөнгө</b>	<b>25,118.6</b>	<b>25,969.4</b>	<b>850.8</b>
Барилга, байгууламж, орон сууц	2,295.6	2,295.6	-
Хуримтлагдсан элэгдэл	(325.2)	(382.7)	(57.5)
Авто-тээврийн хэрэгсэл	91.9	91.9	-
Хуримтлагдсан элэгдэл	(91.9)	(91.9)	-
Машин тоног төхөөрөмж(компьютер)	30,458.5	33,718.6	3,260.1
Хуримтлагдсан элэгдэл	(12,535.7)	(14,811.1)	(2,275.4)
Тавилга, аж ахуйн эд хогшил	6,758.1	7,264.4	506.3
Хуримтлагдсан элэгдэл	(1,713.9)	(2,310.2)	(596.3)
Бусад үндсэн хөрөнгө	3.6	4.6	1.0
Хуримтлагдсан элэгдэл	(1.9)	(2.2)	(0.3)
Ном	179.4	192.4	13.0
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>2,050.2</b>	<b>2,050.2</b>	<b>-</b>
Программ хангамж	1,234.4	1,234.4	-
Хуримтлагдсан элэгдэл	(550.6)	(687.0)	(136.4)
Бусад биет бус хөрөнгө	815.8	815.8	-
Хуримтлагдсан элэгдэл	(112.4)	(191.1)	(78.7)
<b>Дүн</b>	<b>26,505.8</b>	<b>27,141.6</b>	<b>635.8</b>

Эх сурвалж: Улсын Их Хурлын даргын төсвийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаанд хөрөнгө оруулалтын санхүүжилтээр 4,014.2 сая төгрөг, урсгал төсвийн санхүүжилтээр 208.0 сая төгрөгийн хөрөнгө худалдан авсан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 115 дугаар тогтоолын дагуу Хил

Монгол Улсын Их Хурлын даргын төсвийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

хамгаалах ерөнхий газарт 17 нэр төрлийн, нийт 174 ширхэг, 441.9 сая төгрөгийн үнэтэй, 427.2 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй хөрөнгийг балансаас баланст шилжүүлсэн, тайлант хугацаанд 3,571.8 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

Улсын Их Хурлын Тамгын газар 26,831.9 сая төгрөг, Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэн 309.6 сая төгрөгийн цэвэр хөрөнгөтэй ба нийт үндсэн хөрөнгийн 95.5 хувийг биет хөрөнгө, 4.5 хувийг биет бус хөрөнгө тус тус эзэлж байна.

**Аудитын илрүүлэлт:**

Үндсэн хөрөнгийн данстай холбоотой 91.9 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Үүнд: Улсын Их Хурлын тамгын газрын дансанд 91.9 сая төгрөгийн үнэтэй, элэгдлээ бүрэн нөхсөн Landcruiser 200 тээврийн хэрэгслийг 45.0 сая төгрөгөөр үнэлж, Засгийн газрын автобааз ТӨҮГ-т шилжүүлэх Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 638 дугаар тогтоолыг хэрэгжүүлээгүй, автомашиныг шилжүүлээгүй, мөн элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн 1620 ширхэг тавилга, эд хогшлын үнийг шинэчлэн тогтоож, ашиглалтыг сайжруулах талаар арга хэмжээ аваагүй.

**3.4.5 Өр төлбөр**

Өр төлбөр дансны үлдэгдэл 633.8 сая төгрөг болж 358.8 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 7. Нийт өр төлбөрийн үлдэгдэл*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг	22.2	0.0	(22.2)
Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	-	
Байгууллагад төлөх өглөг	2.1	6.5	4.4
Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	967.2	611.2	(356.0)
Хувь хүмүүст төлөх өглөг	1.1	16.1	15.0
<b>Дүн</b>	<b>992.6</b>	<b>633.8</b>	<b>(358.8)</b>

*Эх сурвалж: Улсын Их Хурлын даргын төсвийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан*

Нийт өглөгийн бүтцийг ангилбал 16.1 сая төгрөг нь албан хаагчдын цалин, түүнтэй холбогдох тооцооны өглөг, 6.5 сая төгрөг нь байгууллагад төлөх зардлын тооцооны өглөг, 611.2 сая төгрөг нь хөрөнгө бэлтгэхтэй холбоотой тооцооны өглөгөөс бүрдэж байна.

Улсын Их Хурлын Тамгын газарт 611.2 сая төгрөг, Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнд 16.4 сая төгрөг, Парламентын институцийг бэхжүүлэх төсөлд 6.2 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байна.

**Аудитын илрүүлэлт:**

Өглөгийн данстай холбоотой 119.4 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Үүнд: Улсын Их Хурлын тамгын газар 2024 онд үүссэн 3 харилцагчтай холбоотой он дамжсан 119.4 сая төгрөгийн өглөгийг барагдуулаагүй, жилийн эцэст тооцоо нийлж, үлдэгдлийг актаар баталгаажуулаагүй.

**3.4.6 Засгийн газрын хувь оролцоо**

Засгийн газрын хувь оролцооны дансны эцсийн үлдэгдэл 28,977.9 сая төгрөг болж, өмнөх оноос 2,011.5 сая төгрөгөөр буурсан.

*Хүснэгт 8. Засгийн газрын хувь оролцоо*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын хувь оролцоо	30,989.4	28,977.9	(2,011.5)
<b>Дүн</b>	<b>30,989.4</b>	<b>28,977.9</b>	<b>(2,011.5)</b>

*Эх сурвалж: Улсын Их Хурлын даргын төсвийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан*

Энэ нь тайлант жилийн үр дүнгээс шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн ерөнхийлөн захирагч 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 191,022.2 сая төгрөгөөр тооцон улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөж, Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 20,719.8 сая төгрөгөөр бууруулж, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар төсвийн ерөнхийлөн захирагчийн зарцуулах төсвийг 170,302.4 сая төгрөгөөр баталсан байна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд орсон 1 удаагийн тодотголоор төсвийг 8,281.9 сая төгрөгөөр бууруулж, төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг 162,020.5 сая төгрөгөөр улсын төсвөөс санхүүжүүлэхээр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

##### Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн зарцуулалт

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 156,987.2 сая төгрөгийн санхүүжилт авч, өөрийн үйл ажиллагаанаас 140.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 124,675.7 сая төгрөгийг зарцуулж, зарцуулагдаагүй 30,452.4 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 124,675.7 сая төгрөг буюу 77.0 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагаа зардлын төсвийг 37,344.9 сая төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 9. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	70102	Хууль тогтоох, хуулийн хэрэгжилт	162,020.5	124,675.7	37,344.9	77.0
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	74,261.4	49,172.3	25,089.1	66.2
1.2	80103	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	9,504.9	8,791.2	713.7	92.5
1.3	80108	УИХ-н гишүүний төсөв	63,175.3	57,994.3	5,181.0	91.8
1.4	80205	Мэдээлэл, сурталчилгааны зардал	2,518.1	1,998.9	519.2	79.4
1.5	80509	ОУ-ын байгууллагын гишүүнчлэл хураамж	55.8	55.8	-	100.0
1.6	80704	Ахмад дайчин, алдар цолтой ахмад дайчдад олгох тэтгэмж,	374.7	222.3	152.4	59.3
1.7	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	2,819.5	514.6	2,304.9	18.3
1.8	80815	Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн албан хаагчид олгох тэтгэмж	750.8	652.0	98.7	86.8
1.9	80918	Бусад	8,560.0	5,274.1	3,285.9	61.6

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

## **Ерөнхий чиглэлийн судалгаа**

### *Байгууллагуудын орон тооны цомхотголын талаар:*

Засгийн газрын 2025 оны “Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” 7 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар нийт орон тоог 9.0 хувиар бууруулахаар баталсныг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Тухайлбал: Монгол Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын 2025 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн “Монгол Улсын Их хурлын Тамгын газрын зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарын шинэчлэн батлах тухай” 645 дугаар захирамжаар орон тоог 257 байхаар баталсан, мөн Монгол Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын 2025 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн “Парламентын судалгаа хөгжлийн хүрээлэн зохион байгуулалтын бүтэц, орон тоо албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай захирамжийн хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 771 дугаар захирамжаар хүрээлэнгийн бүтцийг 50 орон тоотой байхаар тус тус баталсан байна.

### *Унаа, хоолны хөнгөлөлтийн зардлын тарифын судалгааны үр дүнгийн талаар:*

Улсын Их Хурлын даргын эрхлэх асуудлын хүрээний 2 төсвийн шууд захирагч унаа, хоолны зардлын хэмжээг 2025 оны 2 дугаар сараас эхлэн нэмэгдүүлж, нэг өдрийн хоолны зардлыг 32,000 төгрөг, унааны зардлыг 2,000 төгрөг байхаар тогтоож, нийт унаа, хоолны зардалд 2,443.2 сая төгрөг олгосон. Парламентын институцийг бэхжүүлэх төсөл нь хоол, унааны хөнгөлөлт олгоогүй байна.

### *Гадаад томилолтын, арга хэмжээний судалгааны үр дүнгийн талаар:*

Улсын Их Хурлын даргын эрхлэх асуудлын хүрээний 3 байгууллага гадаад томилолтын 75 арга хэмжээнд зориулж 4,618.3 сая төгрөг төлөвлөснөөс, гүйцэтгэлээр 75 арга хэмжээнд 1,313,5 сая төгрөгийг зарцуулсан. Зочин төлөөлөгч хүлээн авах зардалд 3,093.1 сая төгрөг төлөвлөснөөс, гүйцэтгэлээр 12 арга хэмжээнд 2,431.2 сая төгрөгийг зарцуулсан байна.

### *Сургалт семинар хурал зөвлөгөөний судалгааны үр дүнгийн талаар:*

Тус даргын эрхлэх асуудлын хүрээний 3 байгууллага тайлант онд 33 сургалт семинар, хурал зөвлөгөөнд зориулж 581.7 сая төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 33 арга хэмжээнд зориулж 566.3 сая төгрөгийг зарцуулсан байна.

### *Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний гэрээ, төлбөрийн судалгааны үр дүнгийн талаар:*

Улсын Их Хурлын даргын эрхлэх асуудлын хүрээний 2 байгууллага 289 хэвлэл мэдээллийн байгууллагатай, нийт 2,088.3 сая төгрөгийн ажил, үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулж, гэрээний төлбөрт 2,063.8 сая төгрөгийг олгосон байна.

#### **3.5.3 Хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, хэрэгжилт**

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар тус төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд 11 арга хэмжээний зорилтот түвшнийг тусгажээ. Хөтөлбөр, хүрэх үр дүн нь 100.0 хувийн гүйцэтгэлтэй, зорилтот түвшиндээ хүрсэн гэж тайлагнасан байна. Хөтөлбөрийн хүрээнд батлагдсан төсвийн гүйцэтгэл 162,020.5 сая төгрөг төлөвлөснөөс 124,675.7 сая төгрөг зарцуулж, 77.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

#### **3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Тус төсвийн ерөнхийлөн захирагч нь худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа ТБОНӨХБАҮХАТ хуулийн 3 дугаар зүйлийн 3.3-т “Энэ хууль бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбоотой дараах харилцааг зохицуулахад хамаарахгүй” 3.3.1-т “хуулиар төрийн

нууцад хамааруулсан болон үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой тусгай зориулалтын тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, техник, байгууламж, ажил, үйлчилгээ болон галт зэвсэг худалдан авах ажиллагаа” гэсэн заалтыг баримтлан Засгийн газрын худалдан авах ажиллагааг зохион байгуулах сургалтад хамрагдсан АЗ сертификаттай алба хаагчдаас бүрдсэн ажлын хэсгийг томилж, харьцуулалтын аргыг ашиглан худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна.

### 3.5.5 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр Улсын Их Хурлын Тамгын газарт “Парламентын институцийг бэхжүүлэх нь” төсөл хэрэгжүүлсэн. Энэ төсөл нь 2024 оны 04 дүгээр сарын 01-ээс 2026 оны 03 дугаар сарын 31-ний хооронд хэрэгжиж дуусна. “Парламентын институцийг бэхжүүлэх нь” Монгол Улсын Үндсэн хууль, Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгад оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хэрэгжилтийн хүрээнд парламентын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, Улсын Их Хурлын Тамгын газрын чадавхыг бэхжүүлэх замаар дараах гурван үр дүнд хүрэхээр төлөвлөсөн байна. Үүнд:

- Үр дүн 1: Улсын Их Хурлын Тамгын газрын бодлогын үнэлгээг үр дүнтэй хийх чадавх, арга аргачлалтай болсон байна.
- Үр дүн 2: Улсын Их Хурал нь хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх чадавх, бүтэц, үр дүнтэй арга, аргачлалтай болсон байна.
- Үр дүн 3: Хүний эрхийг дээдэлсэн, жендерийн мэдрэмжтэй хуулийн төсөл боловсруулахад Монгол Улсын Их Хуралд дэмжлэг үзүүлэх Улсын Их Хурлын Тамгын газрын институцийн чадавхыг ОУПХ болон/ эсвэл ХЭДКГ-тай хамтран бэхжүүлнэ.

Хүснэгт 10. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/сая төгрөгөөр/

№	Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн нэр	Хэрэгжих хугацаа	Нийт төсөв	Зарцуулсан
1	“Парламентын институцийг бэхжүүлэх нь” төсөл	2025 он	512.0	410.5

Эх сурвалж: Улсын Их Хурлын даргын төсвийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Монгол Улсын Их Хурлын даргын төсвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд төсвийн ерөнхийлөн захирагч, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, эд хөрөнгийн тооллогыг Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан" Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын дагуу бэлтгэх, Архивын баримтын бүрдүүлэлт, бүртгэл, хадгалалт, ашиглалтын үйл ажиллагааг хуульд заасны дагуу бүрдүүлэх, Судалгааны ажлын төсвийг багцлан тендер зарлах зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын аудитор Г.Батбилэг гүйцэтгэж, үе шатны хяналтыг аудитын менежер В.Эрдэнэцогт, Тусгай чиг үүргийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Баярсайхан нар тус тус хэрэгжүүлсэн.

Улсын Их Хурлын даргын төсвийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн ТГ-01/336 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 4.2 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг сонгосон суурь үзүүлэлт 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 130,741.2 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 1,307.4 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3-д “Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтад заасан албан тушаалтанд энэ хууль хамаарахгүй” гэж заасан байна.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн аудитын асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд оруулбал зохих мэдээллээс Монгол Улсын Их Хурлын Тамгын газар болон Парламентын судалгаа хөгжлийн хүрээлэн 62.7 сая төгрөгийн гүйлгээг шилэн дансанд ил тод мэдээлээгүй зөрчил илэрсэнд 1 зөвлөмж, 1 албан шаардлага хүргүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилоор шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалтуудтай нийцээгүй гэж дүгнэсэн.

#### 4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 14.8 сая төгрөгийн 5 зөрчилд 1 төлбөрийн акт, 1 албан шаардлага 3 зөвлөмж өгсөн, хэрэгжилтийг Улсын Их Хурлын Тамгын газрын Санхүү, хангамж үйлчилгээний хэлтсийн даргын 2025 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн ТГ-05/1343 албан бичгээр ирүүлсэн.

Хүснэгт 11. Зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөгөөр/

Дд	Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
1	Төлбөрийн акт	1	0.6	1	0.6	100.0
2	Албан шаардлага	1	14.2	1	9.6	67.6
3	Зөвлөмж	3	0	3	0	100.0
	<b>Нийт дүн</b>	<b>5</b>	<b>14.8</b>	<b>5</b>	<b>10.2</b>	<b>68.9</b>

Жилийн эцсийн аудитаар хэрэгжилтийг хянахад 1 төлбөрийн акт, 3 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, авлагын үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулж байх албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй тул дараагийн шийдлийг сонгосон.

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Тус төсвийн ерөнхийлөн захирагчийн хөрөнгө оруулалтын ажил нь байгууллагын “маш нууц”-ийн зэрэгт хамаарч байгаа тул зөвхөн санхүүгийн тайлагналын түвшинд үзсэн бөгөөд тендер сонгон шалгаруулалт болон хөрөнгө оруулалтын ажлын үр дүнг гүйцэтгэлийн аудитаар анхаарч үзэх, мөн хэвлэл мэдээллийн зардлын гүйцэтгэл нь өмнөх жилүүдтэй харьцуулахад өссөн үзүүлэлттэй байгаад анхаарах хэрэгтэй.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 1 төслийн санхүүгийн тайлан нэгтгэсэн.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар санхүүгийн асуудлаар нийт 571.2 сая төгрөгийн 11 зөрчил илэрч, 438.6 сая төгрөгийн 8 албан шаардлага, 13.1 сая төгрөгийн 1 хариуцлага тооцох албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй байх талаар 119.5 сая төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн 571.2 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон 1,307.4 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

### 5.1 Харьяа байгууллагууд

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 1 төслийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан байна.

Харьяа 3 байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 571.2 сая төгрөгийн 11 зөрчил илэрч, 438.6 сая төгрөгийн 8 албан шаардлага, 13.1 сая төгрөгийн 1 хариуцлага тооцох албан шаардлага, 1 хариуцлага тооцох албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй байх талаар 119.5 сая төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлсэн.

### 5.2 Төсвийн ерөнхийлөн захирагч

Төсвийн ерөнхийлөн захирагчийн аудитаар 1 зөвлөмж хүргүүллээ.

#### 5.2.1 Зөвлөмж

1.Илрүүлэлт: Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх дотоод аудитын нэгжээс тавих хяналт хангалтгүйгээс харьяа 2 байгууллагын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар санхүүгийн асуудлаар 571.2 сая, бусад нийцлийн асуудлаар 62.7 сая төгрөг нийт 633.8 сая төгрөгийн зөрчил илэрснээс 501.3 сая төгрөгийн зөрчилд 9 албан шаардлага, 119.4 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгч, 13.1 сая төгрөгийн зөрчилд 1 хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 14 дүгээр зүйлийн 14.2-т "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: ... 14.2.10-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэсэн заалттай тус тус нийцээгүй

Өгсөн зөвлөмж: Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүү, төсвийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулах, эрсдэлд суурилсан дотоод хяналт шалгалтын төлөвлөгөө батлуулж, гүйцэтгэлийг хангаж ажиллах.

### 5.3 Түүвэрт хамрагдсан байгууллагууд

#### 5.3.1 Албан шаардлага

1. Улсын Их Хурлын Тамгын газрын дансанд бүртгэлтэй 91.9 сая төгрөгийн үнэтэй, элэгдлээ бүрэн нөхсөн “Landcruiser 200” тээврийн хэрэгслийг 45.0 сая төгрөгөөр үнэлж, Засгийн газрын автобааз ТӨҮГ-т шилжүүлэх Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 638 дугаар тогтоолыг хэрэгжүүлээгүй, автомашиныг шилжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь дараах бүрэн эрхтэй: 8/ "төрийн өмчит хуулийн этгээдийн үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг данснаас хасах санал, захиалгыг хянаж батлах, шинээр авах шийдвэр гаргах", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 12 дугаар сарын 5-ны 638 дугаар "Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай" тогтоолын 1 дүгээр заалтыг тус тус хэрэгжүүлээгүй.

**Шийдвэрлэсэн нь:** Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тогтоолыг хэрэгжүүлж, автомашиныг шилжүүлээгүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

2. Улсын Их Хурлын Тамгын газар өмнөх оноос он дамжсан 4.6 сая төгрөг, тайланд онд шинээр үүссэн 8.5 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцээгүй.

**Шийдвэрлэсэн нь:** Жилийн эцсээр авлагыг үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулдаггүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан албан тушаалтанд сахилгын шийтгэл оногдуулах албан шаардлага хүргүүлсэн.

3. Парламент судалгаа, хөгжлийн хүрээлэн автомашингүй, байгууллагын дарга Засгийн газрын авто баазаас албан тушаалтын авто машин унаж 63.0 сая төгрөгийн зардал гаргасан байхад байгууллагын орон тоо бүтцэд 2 жолоочийн орон тоог баталж, ажиллуулан 102.2 сая төгрөгийн цалин олгож, Нийгмийн даатгалын шимтгэлд ажил олгогчоос 12.3 сая төгрөгийг тус тус төлж төсвийг үрэлгэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9-д "хариуцлагатай байх", 4.1.3-т "үр ашигтай байх", 15 дугаар зүйлийн 15.2.6-д "байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох" гэсэн заалттай тус тус нийцээгүй.

**Шийдвэрлэсэн нь:** Авто баазаас албан тушаалын автомашин хэрэглэдэг байж, давхар жолоочийн орон тоо баталж, цалингийн зардал болон нийгмийн даатгалын шимтгэл төлж төсвийг үрэлгэн зарцуулсан зөрчлийг таслан зогсоох, албан шаардлага хүргүүлсэн.

4. Парламент судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн бодлогын зөвлөлийн дарга нь албан тушаалын автомашин унах эрхгүй бөгөөд албан ажил гүйцэтгэхдээ хувийн автомашинд 2.8 сая төгрөгийн шатахуун олгож, төсвийг үрэлгэн зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т "Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын тэргүүн дэд, дэд, орлогч дарга болон дэд сайд, яамны төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн захирал, төсвийн байгууллагын дарга хот дотор албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно" гэсэн заалттай тус тус нийцээгүй.

**Шийдвэрлэсэн нь:** Албан тушаалын автомашин ашиглах эрхгүй албан тушаалтанд шатахуун олгодог зөрчлийг таслан зогсоох, албан шаардлага хүргүүлсэн.

5. Тус хүрээлэн нь "Өсвөрийн парламент"-д оролцогч сурагчид, Нээлттэй парламент оюутны дадлагажигч хөтөлбөрт оролцогчид болон Олон Улсын Эрдэм Шинжилгээний Хурал, гадаадын зочин төлөөлөгчдийг хүлээн авахад 20.5 сая төгрөгийн гарын бэлэг өгсөн.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.5-д "Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах" гэсэн заалттай тус тус нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлж, бэлэг өгдөг зөрчлийг таслан зогсоох, албан шаардлага хүргүүлсэн.

6. Парламентын судалгаа хөгжлийн хүрээлэнгийн захирлын 2025 оны А/02 дугаар тушаалаар гаднын байгууллагын ажилтнуудад орон нутагт томилолтоор ажиллах хугацааны зардалд зориулан 29.4 сая төгрөгийг тус байгууллагын төсвөөс зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалттай нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын төсвөөс гаднын байгууллагын ажилтнуудад томилолт олгодог зөрчлийг таслан зогсоох, албан шаардлага хүргүүлсэн.

7. Парламентын судалгаа хөгжлийн хүрээлэн нь Улсын Их Хурлын Тамгын газрын данс бүртгэлд байдаг, конторын барилгын засварт 239.3 сая төгрөгөөр засвар хийж, урсгал засварын зардлын төлөвлөгөөг 39.3 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 18 дугаар зүйлийн 18.1.2-т "төсвийн байгууллагын зардал, арга хэмжээг ач холбогдлоор нь эрэмбэлэн төсвийн сар, улирлын хуваарьт зохицуулалт хийж санхүүжүүлэх", 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэсэн заалттай тус тус нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь: Урсгал засварын зардлын төсвийг хэтрүүлэн зарцуулдаг зөрчлийг таслан зогсоох, албан шаардлага хүргүүлсэн.

8. Парламентын судалгаа хөгжлийн хүрээлэн "Lexology" буюу олон улсын хуулийн судалгааны сангийн 15,000.00 ам.долларын үнэтэй программыг 1 жилийн хугацаатай худалдан авсан бөгөөд төлбөрийг 3 хувааж шилжүүлсэн байна. Эхний төлбөр болох 5,000.00 ам.долларыг 2024 оны 12 дугаар сарын 09-ний өдөр, дараагийн төлбөрийг 2025 оны 4 дүгээр сарын 7-ны өдөр тус тус төлсөн байна. Үлдэгдэл 5,000.00 ам долларын төлбөрийг мөн Төрийн сангаар дамжуулан шилжүүлж болох байтал Lexology хуулийн судалгааны сан байгуулах нэртэй тендер сонгон шалгаруулалт зарлаж, нэг компани оролцож Вертуал линк ХХК-ийг шалгаруулсан бөгөөд 69.8 сая төгрөгөөр гэрээ байгуулсан. Вертуал линк ХХК нь өмнөх онд байгуулсан 1 жилийн хугацаатай гэрээний төлбөрийн үлдэгдэл 5,000.00 ам доллар, шинээр байгуулсан гэрээний төлбөр буюу 2025 оны 12 дугаар сарын 2-ны өдрөөс 2026 оны 6 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацааны төлбөрт 10,000 ам.доллар, нийт 15,000.00 ам.доллар буюу 53.7 сая төгрөгийг Худалдаа Хөгжлийн Банкаар дамжуулан төлж, зөрүү 16.1 сая төгрөгийг үйлчилгээний бусад зардалд өгч, төсвийг үрэлгэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9-д "хариуцлагатай байх", 4.1.3-т "үр ашигтай байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь: Гаднын байгууллагад төлбөр шилжүүлэх үндэслэлээр тендер зарлаж төлбөрөөс бусад, нэмэлт зардал гаргаж төсвийг үр ашиггүй үрэлгэн зарцуулдаг зөрчлийг таслан зогсоох, албан шаардлага хүргүүлсэн.

9. Парламентын судалгаа хөгжлийн хүрээлэн нь 2025 оны 5 дугаар сард "ChatGPT хиймэл оюун ухааны чатбот үйлчилгээ үзүүлэх" 70.0 сая төгрөгийн тендер сонгон шалгаруулалтыг зарлаж, 2 компани оролцсоноос Гөү смарт ТМ ХХК-ийг шалгаруулж, 2025 оны 6 дугаар сарын 13-ны өдөр 1 жилийн хугацаатай ашиглах хиймэл оюун ухааны чатботын гэрээг байгуулсан бөгөөд урьдчилж төлсөн зардлаар бүртгээгүй байна. Тус гэрээний тендерийн баримт бичигт чатбот үйлчилгээний хэдэн эрхийг ямар үнэ өртгөөр авч байгааг тодорхой тусгаагүй байна. Чатбот эрхийг сар, улирлаар төлбөрийг төлж, Open AI компаниас шууд худалдан авах боломж байгааг судлаагүй төсвийг үрэлгэн зарцуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-т "Оролцогчийг тендер бэлтгэж ирүүлэхэд шаардагдах мэдээлэл, оролцогчид тавих шаардлага, заавар, хамгийн сайн тендерийг шалгаруулах шалгуур үзүүлэлт, аргачлал, захиалагчийн санал болгож байгаа гэрээний нөхцөлүүд, техникийн тодорхойлолт, тендерийн жишиг маягыг тендер шалгаруулалтын баримт бичигт тусгана.", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9-д "хариуцлагатай байх", 4.1.3-т "үр ашигтай байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь: Чатбот эрхийг шууд худалдан авах боломж байгааг судлаагүй, төсвийг үрэлгэн зарцуулсан зөрчлийг таслан зогсоох, албан шаардлага хүргүүлсэн.

### 5.3.2 Зөвлөмж

#### Илрүүлэлт 1:

Улсын Их Хурлын Тамгын газар 2024 онд үүссэн 3 харилцагчтай холбоотой он дамжсан 119.4 сая төгрөгийн өглөгийг барагдуулаагүй, 2025 оны жилийн эцэст тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулаагүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай нийцээгүй.

Өгсөн зөвлөмж: Жилийн эцэст өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулж байх.

#### Илрүүлэлт 2:

Улсын Их Хурлын Тамгын газар элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн 1620 ширхэг тавилга, эд хогшлын үнийг шинэчлэн тогтоож, ашиглалтыг сайжруулах талаар арга хэмжээ аваагүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "жинхэнэ хэрэгжилтийн", 5.1.4-т "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3 холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай тус тус нийцээгүй. 2024 онд үүссэн 3 харилцагчтай холбоотой он дамжсан 119,416.3 мянган төгрөгийн өглөгийг барагдуулаагүй, 2025 оны жилийн эцэст тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулаагүй.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн тавилга, эд хогшлын үнийг шинэчлэн тогтоох саналыг эрх бүхий байгууллагад хүргүүлж, ашиглалтыг сайжруулах талаар анхаарч ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

### 6.1 Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу бүртгэсэн илэрхийлэл		Үүнээс					
							Залруулсан		Залруулаагүй		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Улсын Их хурлын тамгын газар	1	33.8	1	33.8	-	-	1	33.8	-	-	-	-
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>33.8</b>	<b>1</b>	<b>33.8</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>33.8</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

### 6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Улсын их хурлын дарга	1	-							1	-		
Улсын их хурлын Тамгын газар	4	224.4	-	-	1	91.9	2	119.5	1		13.1	
Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэн	7	346.7	-	-	7	346.7	-	-	-		-	
<b>Дүн</b>	<b>12</b>	<b>571.2</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>8</b>	<b>438.6</b>	<b>3</b>	<b>119.5</b>	<b>1</b>		<b>13.1</b>	

### 6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Алдаа, зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Улсын Их Хурлын Тамгын газар	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Парламент судалгаа, хөгжлийн хүрээлэн	1	62.7	-	-	1	62.7	-	-	-	-	-	-
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>62.7</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>62.7</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>